



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/24

Мандагговь

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд,  
сэтгэлзүйн оношлогоо, дүгнэлт гаргуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.1.1, 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5, 10.1.6, 10.2, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5, 11.6 12 дугаар зүйлийн 12.4, 14 дүгээр зүйлийн 14.1, 19 дүгээр зүйлийн 19.1.1, 19.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/23, 27 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. БХ-2022032403 дугаартай кейст "Монгол-өрх" сэтгэлзүйн хүрээлэнтэй хамтран сэтгэлзүйн оношлогоо, дүгнэлт гаргуулсугай.
2. БХ-2022032403 дугаартай кейст хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.
3. Хүүхдийн эрхийн зөрчлийн гомдол мэдээллийг хүлээн авах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх ажлыг хүүхдэд ээлтэй, аюулгүй байдлыг ханган зохион байгуулж, кейс менежментийн явцад хяналт тавьж, хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж ажиллахыг Хүүхэд хамгааллын мэргэжилтэн (Б.Цэцэг)-д үүрэг болгосугай.
4. Үйл ажиллагаанд шаардагдах 250,000 (Хоёр зуун тавин мянга) төгрөгийг Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.
5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулж, ажиллахыг хүүхэд хамгааллын мэргэжилтэн (Б.Цэцэг)-д даалгасугай.

ДАРГА

Ц.ГАНЗОРИГ

• 482201045

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,  
залуучуудын хөгжлийн газрын даргын  
2022 оны 4-р дүгээр сарын 11-ны өдрийн  
АЯЛ тоот тушаалын 6.1 дүгээр хавсралт



ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЗАРДАЛД ШААРДАГДАХ ТӨСӨВ

| №                                     | Хэрэглэгдэхүүн                                   | Тоо<br>хэмжээ | Нэг бүрийн<br>үнэ | Хэдэн<br>удаа | Нийт үнэ |
|---------------------------------------|--------------------------------------------------|---------------|-------------------|---------------|----------|
| Сэтгэлзүйн оношлогоо, дүгнэлт хийлгэх |                                                  |               |                   |               |          |
| 1                                     | Сэтгэлзүйн оношлогоо,<br>дүгнэлт хийлгэх уулзалт | 1             | 50,000            | 5             | 250,000  |
| Нийт                                  |                                                  |               |                   |               | 250,000  |

-----oOo-----